“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-ИЙН 2025 ОНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОВЧ ТЭМДЭГЛЭЛ

Хувьцаа эзэмшигчийн хурал болсон огноо, газар: 2025 оны 04 дүгээр сарын 21 -ний өдөр “Монголын хөрөнгийн бирж” ХК -ийн ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурал “Монголын хөрөнгийн бирж” ХК -ийн төв байрны 1 давхарт танхим болон цахим хосолсон хэлбэрээр 10 цаг 00 минутаас 12 цаг 30 минутын хооронд 2 цаг 30 минутын турш болж өндөрлөлөө.

Хурлын ирц: Хуралд “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн саналын эрхтэй нийт 350,463,539 ширхэг хувьцаанаас 68.76 хувь буюу 240,991,242 ширхэг хувьцаа эзэмшиж буй 64 хувьцаа эзэмшигч оролцож, ирц баталгаажсан.

Хуралд оролцсон төлөөллүүд:

Монгол Улсын Сангийн яам:

Санхүү бодлогын газрын Санхүүгийн бодлогын газрын мэргэжилтэн – Ш.Бат-эрдэнэ

Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын Санхүүгийн хяналт шалгалтын хэлтсийн дарга – Ж.Цогтбаяр

“Монголын хөрөнгийн бирж” ХК -ийн Төлөөлөн удирдах зөвлөл:

ТУЗ -ийн дарга - Д.Тогтохбаяр
Ердийн гишүүн - Ж.Цогтбаяр
Ердийн гишүүн - Ж.Бямбасүрэн
Хараат бус гишүүн - М.Банзрагч
Хараат бус гишүүн - Н.Улаанхүү
Хараат бус гишүүн - Г.Отгончимэг

“Монголын хөрөнгийн бирж” ХК -ийн Хяналтын зөвлөл:

Хяналтын зөвлөлийн гишүүн – Д.Батбаяр

“Монголын хөрөнгийн бирж” ХК:

Захиргаа, санхүүгийн газрын захирал - Х.Эрдэнэбүрэн
Хяналт, шинжилгээний газрын захирал - А.Мөнхбаясгалан
Үйл ажиллагааны газрын захирал - И.Жавхлан
Бизнес хөгжлийн газрын захирал – Т.Хаш-эрдэнэ
Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаа бүртгэлийн газрын захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч – С.Ариунсанаа

“Грант торнтон аудит” ХХК

Ахлах аудитор - Г.Анужин

Хувьцаа эзэмшигчийн ээлжит хурал нь дараах хөтөлбөрийн дагуу явагдлаа.

1. Тооллогын комиссын дарга С.Дөлгөөн хурлын ирцийг танилцуулав. Хурлын ирц 64 хувьцаа эзэмшигч оролцож саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн хувь 68.76% -д хүрснээр хурлыг эхлүүлэв.
2. Хурлын дарга Д.Тогтохбаяр хурлыг нээж, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулав.
3. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг ТУЗ -ийн дарга Д.Тогтохбаяр танилцуулав.
4. Компанийн 2025 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний саналыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Дөлгөөн танилцуулав
5. Компанийн үндсэн үйл ажиллагаанд ашигладаг системийн талаар авах зарим арга хэмжээний тухай Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Дөлгөөн танилцуулав.
6. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин хөлсийг тогтоох тухай асуудлыг ТУЗ-ийн дарга Д.Тогтохбаяр танилцуулав.
7. Хяналтын зөвлөлийн гишүүдийг сонгох тухай асуудлыг ТУЗ-ийн дарга Д.Тогтохбаяр танилцуулав.
8. Хурлаар хэлэлцэх асуудал тус бүрээр хэрхэн санал өгөх талаарх видео зааврыг танилцуулах Тооллогын комиссын дарга С.Дөлгөөн танилцуулав.
9. Нийт 6 хувьцаа эзэмшигч танилцуулгатай холбоотой асуулт асуух хариултыг холбогдох албан тушаалтнуудаас авав.
10. Санал хураалт 11 цаг 55 минутаас 12 цаг 10 минут хүртэл 15 минутын хугацаанд үргэлжлэв.
11. Санал хураалтын дүнг тооллогын комиссын дарга С.Дөлгөөн танилцуулав.
12. Хурлын дарга Д.Тогтохбаяр хурлыг хааж үг хэлэв.

Хөтөлбөрийн хүрээнд "Монголын хөрөнгийн бирж" ХК -ийн ээлжит хурлаар хэлэлцэн баталсан асуудлууд:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. Компанийн 2025 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний саналыг хэлэлцэж батлах;
3. Компанийн үндсэн үйл ажиллагаанд ашигладаг системийн талаар авах зарим арга хэмжээний тухай;
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин хөлсийг тогтоох тухай;
5. Хяналтын зөвлөлийн гишүүдийг сонгох тухай.

Тооллогын комиссын тогтоолоор:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудалд хүчинтэй саналын хуудас өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 99.980 хувь зөвшөөрсөн, 0.0000 хувь татгалзсан, 0.0199 хувь түдгэлзсэн.

2. Компанийн 2025 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний саналыг хэлэлцэж, батлах тухай асуудалд хүчинтэй саналын хуудас өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 99.967 хувь зөвшөөрсөн, 0.0003 хувь татгалзсан, 0.0329 хувь түдгэлзсэн.
3. Компанийн үндсэн үйл ажиллагааны системийн талаар авах зарим арга хэмжээний тухай асуудалд хүчинтэй саналын хуудас өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 99.967 хувь зөвшөөрсөн, 0.0000 хувь татгалзсан, 0.0329 хувь түдгэлзсэн.
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин хөлсийг тогтоох тухай асуудалд хүчинтэй саналын хуудас өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 99.959 хувь зөвшөөрсөн, 0.0076 хувь татгалзсан, 0.0329 хувь түдгэлзсэн.
5. Хяналтын зөвлөлд нэр дэвшсэн таван нэр дэвшигчээс дараах гурван нэр дэвшигч хамгийн өндөр саналаар эрэмбэлэгдэн сонгогдлоо. Үүнд:

- Нэр дэвшигч Ж.Ариунгэрэлд хүчинтэй саналын хуудас өгсөн нийт хувьцаа эзэмшигчдээс зөвшөөрсөн 99.497%, татгалзсан 0.4700%, түдгэлзсэн 0.0333%,
- Нэр дэвшигч С.Хуланд зөвшөөрсөн 99.617%, татгалзсан 0.1682%, түдгэлзсэн 0.2140%,
- Нэр дэвшигч Д.Ганзоригт зөвшөөрсөн 99.503%, татгалзсан 0.4960%, түдгэлзсэн 0.0003%,
- Б.Баттулгад зөвшөөрсөн 0.847%, татгалзсан 0.6993%, түдгэлзсэн 98.4542%,
- Б.Энхцэцэгт зөвшөөрсөн 0.5353%, татгалзсан 0.8164%, түдгэлзсэн 98.6483%-ийн саналыг тус тус өгсөн байна.

Шийдвэр: Хурлаас гарсан шийдвэрүүдийг ТУЗ -ийн дарга Д.Тогтохбаяр танилцуулав.

1. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлав.
2. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг батлав.
3. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн үндсэн үйл ажиллагаанд ашигладаг үнэт цаасны арилжааны болон уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны системийн тогтвортой, тасралтгүй, найдвартай, үр ашигтай байдлыг нэмэгдүүлж, сайжруулах зорилгоор зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн.
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүний сарын үндсэн цалинг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү хэмжээгээр тус тус тогтоосон.

   Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хорооны хуралд оролцсон сар бүр үндсэн цалингийн 25 хувьтай тэнцүү хэмжээний нэмэгдлийг тооцохоор баталсан.

5. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Хяналтын зөвлөлийн гишүүнээр дор дурдсан нэр дэвшигчдийг 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн 2027 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл хугацаатайгаар сонгосон.
   Хяналтын зөвлөлийн гишүүн: Ж.Ариунгэрэл
   Хяналтын зөвлөлийн гишүүн: С.Хулан
   Хяналтын зөвлөлийн гишүүн: Д.Ганзориг

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

Хурлын дарга Д.Тогтохбаяр

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Г.Тэмүүжин